

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ОРШИХ “ЗОЛУУХАР” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН.**

/Тусгай зөвшөөрлийн дугаар **MV-012415/**
/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар № **12659603/**

Биелэлтийг тайлагнасан: “ОЧИР УНДРАА ” ХХК-ийн
Гүйцэтгэх захиралГ.Мөнхзул.

Геологи уул уурхайн хэлтсийн дарга.....Б.Ганзориг.

Уул уурхайн инженер :.....Д.Батбаатар



2022 ОН

АГУУЛГА.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн нэр.....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага.....	3
1.3. Төслийн байршил.....	3-4
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	4
1.5. Уурхайн дэд бүтэц.....	4-7
1.5.1. Уурхайн барилга байгууламж.....	4-6
1.5.2. Цахилгаан хангамж.....	6
1.5.3. Усан хангамж.....	6
1.5.4. Зам харилцаа.....	7
1.6. Уурхайн хүчин чадал болон ажиллах хугацаа.....	7-8
1.7. Баяжуулах технологи.....	8
1.8. 2022 оны Уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга.....	8-9
2. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	9
2.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	9
2.2. Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	9
2.3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	9
2.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	10
2.5. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	10
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	11
3.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй.....	11
3.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	11-21
1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	11-20
2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний биелэлт ..	20
3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	20
4. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	21
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	21-24

5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24
6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
7. ХОГ ХАЯГДЛЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ	26

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“ЗООЛУУХАР” алтны шороон орд ашиглах төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

“ОЧИР УНДРАА” ХХК

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **9011122089**

Регистрийн дугаар: **2659603**

Бүртгүүлсэн огноо: **2000.10.30w**

Хаяг: УБ хот, СБДүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, 8/1 Сити Таур 1701 Утас: **75757979 , 99310988**

1.3. Төслийн байршил


“Очир Ундраа” ХХК нь 2022 оноос эхлэн ашигт малтмал ашиглах MV-012415 тусгай зөвшөөрөл бүхий “Зоолуухар” алтны шороон ордод олборлолтын үйл ажиллагааг явуулж байна.

Тус орд нь Дархан-Уул аймгийн Хонгор сумд орших бөгөөд Улаанбаатар хотоос 220 орчим км-т, Дархан-Уул аймгаас зүүн урагшаа 50 км-т, Хонгор сумаас зүүн урагшаа 45 км-т, Шарын гол сумаас баруун хойшоо 7 орчим км-т, 1:100 000-ын масштабтай байр зүйн зургийн М-48-105 тоот хавтгайд оршино.

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нийт 190 га бөгөөд Хонгор сумд хамаарагддаг. Төслийн талбайн солбицолын цэгүүдийг Хүснэгт 1-д, байршлыг Газрын зураг 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Төслийн талбайн булангын цэгийн солбицол

MV-012415-Зоолуу хар		
№	Уртраг	Өргөрөг
1	106° 24' 41.21"	49° 17' 18.41"
2	106° 24' 41.21"	49° 17' 48.91"
3	106° 23' 1.21"	49° 17' 48.91"
4	106° 23' 1.21"	49° 17' 18.41"



Газрын зураг 1. Зоолуухар уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн байршил

1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц

Уул уурхайн зураг төслийн “Эрдэнэс инженеринг” ХХК нь “Зоолуу Хар” алтны шороон ордын В-1-ээс В-15 мөн С-1-ээс С-5 блок хүртэлх нийт 19 блокыг ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулсан батлуулж байсан.

Тус ордыг ашиглах геологийн нөөцөөс ашиглалтын хаягдал, элсний бохирдлыг тооцсоны үндсэн дээр үйлдвэрлэлийн буюу баяжуулах элсний нөөцийн хэмжээ гарна. Уг ордыг ашиглах үйлдвэрлэлийн элсний нөөцийн хэмжээ 233.14 мян.м³, дундаж агуулга 1.03 г/м³, алтны хэмжээ химийн цэврээр 239.91 кг байна.

1.5. Уурхайн дэд бүтэц

1.5.1. Уурхайн барилга байгууламж

Уурхайн тосгон буюу суурьшлын бүс нь нийт 0.7 га талбайг хамарч тусгай зөвшөөрлийн талбайн баруун хойд талд далайн түвшнээс дээш 907 орчим

“Очир Ундраа” ХХК-2022 ОН

метрийн өндөрт талархаг хөндий газарт байрлана. Энд ажилчдын байр, цайны газар, гал тогооны байр, трансформатер зэрэг байгууламжууд байрлах ба эргэн тойрон төмөр торон хашаагаар хашаалсан байна.

Энэ хэсгээр Нугархаг Хархүрэн хөрс зонхилон тархсан байна. Монгол орны бэлчээр хадлангийн ангилаагаар Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нугын бэлчээрийн ангид /УХ-III/ багтах Үндэслэг ишт үетэнт /УХ-II-1/ бүлэг төрлийн, үетэн-алаг өвст /УХ-II-1-1/ хэв шинжийн бэлчээр зонхилно.

Барилга, байгууламж бүхий газар болон авто машины зогоолын хэсгээс бусад газраар хөрсөн бүрхэвчийн эвдрэлгүй, ургамлан нөмрөгийн доройтолгүй байна.

Хүснэгт- 30. Уурхайн тосгоны газар ашиглалтын байдал

№	Газар ашиглалтын төрөл	Талбайн хэмжээ, м2
1	Ажилчдын амралтын байр	214.2
2	Гал тогоо	92.4
3	Цайны газар	192.3
4	Трансформатор	80.7
5	Тосгоны хашааны газар	6314.6
Нийт		6894.2



Зураг2. Уурхайн суурьшлын бүсийн байршил



Зураг3. Уурхайн суурьшлын бүс

1.5.2. Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны гол хэрэглэгч нь угаах төхөөрөмж, усны насосууд, засварын цех, уурхайн тосгон болон бусад жижиг хэрэглэгчид байна.

Зоолуу харын алтны шороон ордын цахилгааны хэрэглээг хангах зорилгоор 2015 онд ЦДҮСүлжээ ХК-ийн Төвийн бүсийн салбарын Шарын гол суманд байрлах 110/6 кВ-ын дэд станцаас Шарын голын уурхайн амралт уруу татсан 6 кВ-ын шугамаас салбарлуулан 6.4 км урт 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 100, 160, 400 кВА дэд станцуудын хамт өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтанд оруулсан байна.

1.5.3. Усан хангамж

Зоолуу харын алтны шороон орд нь Шарын голоос дээш 7.5 км зайд байрладаг. Голын усны түвшин 850.0 м. Ордын хэсэгт газрын гадаргуугийн үнэмлэхүй өндөр 900-960 м буюу Шарын голын усны түвшингээс 50-110 м өндөрт байгаа нь уг орд нь Шарын голтой ямар нэг гидравлик холбоо байхгүй. Хөндийн гадаргуу нь голын зүг бага зэрэг налуу хэлбэртэй. Гадаргуугийн уснаас /шар усны, борооны/ алтны давхарга нь ус үл нэвтрүүлэгч улаан өнгийн шаврын үеэр тусгаарлагдсан байдаг. Хайгуулын ажлын явцад цооногуудад усны 2 үе илэрсэн. Уст давхарга нь 16.0-32.0 м-т байрлах ба

усны ундрага нь 2.4-4.6 л/сек. Усны химийн найрлага нь гидрокарбонат, кальци-магнийн найрлагатай бөгөөд унд ахуйн хэрэгцээнд бүрэн тохирно.

1.5.4. Зам харилцаа

Манай орны эдийн засаг, зам харилцаа, дэд бүтцийн хөгжлөөрөө тэргүүлэх гол муж болох Дархан-Сэлэнгийн дүүрэгт багтах бөгөөд ялангуяа уул уурхайн олборлох үйлдвэр түлхүү хөгжсөн нутаг юм.

Талбайн хэмжээнд орших томоохон суурин газар нь 12000 хүн амтай Шарын гол уурхайн тосгон, Дархан хоттой Шарын гол тосгон нь 65 км төмөр замаар, 50 км урт шороон замаар холбогдоно. Эдгээр суурин газруудад нүүрс олборлох уурхай, алт олборлох салбар, ахуйн үйлчилгээний ба харилцаа холбооны салбар, эмнэлэг, 10-н жилийн сургууль зэрэг үйлдвэр, үйлчилгээ, ахуйн соёлын төвүүд оршино. Шарын гол тосгон нь Улаанбаатар хоттой төмөр зам, автомашины шороон ба цардмал зам, үүрэн холбооны бүх сүлжээнд хамрагдсан өндөр хүчдлийн цахилгаан шугамаар холбогдсон. Нутгийн аль ч хэсэгт жилийн 4-н улиралд автомашинаар явах бүрэн бололцоотой.

1.6. Уурхайн хүчин чадал болон ажиллах хугацаа.

Уурхайн жилийн хүчин чадлыг үндэслэхдээ, уул техникийн нөхцөл, захиалагч байгууллагаас өгсөн уг төслийг боловсруулах техникийн даалгавар зэргийг харгалзан эхний жилд 87.95 мян.м3, удаах жилд 145.2 мян.м3 элс олборлон баяжуулахаар тооцлоо.

Иймээс ил уурхайн нийт ажиллах хугацааг 2 жил байхаар энэхүү техник эдийн засгийн үндэслэлийн тодотголын уулын ажлын календарь төлөвлөгөө болон техник эдийн засгийн тооцоог боловсруулав.

Хүснэгт 2 . Уурхайн нэг ээлжийн ажиллах цагийн горим

Ээлжийн цаг ашиглалтын үзүүлэлтүүд	Нэгж
Ээлж эхлэх, дуусах үзлэг	20.0 минут
Засварын хэсгийн үзлэг	10.0 минут
Цайны цаг	60.0 минут
Шөнийн завсарлага	60.0 минут
Ээлжинд зогсох нийт хугацаа	90.0 минут

Ээлжийн үргэлжлэх хугацаа	12.00 цаг
Бүтээлтэй ажиллах цаг	10.0 цаг
Нөлөөлөл тооцох коэф	87.5%

1.7. Баяжуулах технологи

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Зоолуу харын алтны шороон ордын элсийг угаан баяжуулах технологийн оновчтой хувилбарыг төсөл захиалагч компанийн ажлын даалгавар болон 2017 онд “Ханлаб” ХХК-ийн боловсруулсан технологи туршилтын тайлангийн үр дүнд үндэслэн элсийг скруббер-хоригт цоргын хослолоор угаан баяжуулах болон баяжуулах ширээгээр гүйцээн баяжуулах схемийг сонгосон.

Төсөл хэрэгжүүлэгч “Очир-Ундраа” ХХК нь алтны шороон ордын элсийг олборлон баяжуулах, нөхөн сэргээх тал дээр өмнө ажиллаж байсан туршлагатай бөгөөд ордыг ашиглахад тоног төхөөрөмж, ажиллах хүчний хувьд бүрэн бололцоотой юм.

Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд хүндийн хүчээр ангилан ялгах скруббер болон хоригт цоргоны хослол болох 1 ширхэг СБ-80 маркийн скруббер, гүйцээн баяжуулалтанд баяжуулах ширээ гэсэн үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана.

Элсний том ангилалд байгаа наалдцыг усаар угаан шигшиж ангилсаны дараа алт агуулсан нарийн ширхэгтэй ангилалыг хоригт цоргоор баяжуулан алттай шлихыг ялгаж авна. Угаах төхөөрөмжөөс ялгасан шлихын баяжмалыг гүйцээн боловсруулах цехэд боловсруулна. Гүйцээн ялгалтыг баяжуулах ширээгээр баяжуулах ба дараа нь соронзонгоор хар шлихийг ялгаж цахилгаан зуухан дээр хатааж, тороор шигшин ангилж, ангилал тус бүрийг үлээн ялгана.

1.8. 2022 оны Уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга.

Зоолуухар алтны шороон ордод 2022 оны 7-р сараас ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд үйл ажиллагаа явуулахдаа ТЭЗҮ, БОННУ зэрэг үндсэн баримт бичгүүдэд үндэслэсэн тухайн жилийн Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, газар ашиглах, ус ашиглах дүгнэлт гэрээ, нийгмийн хариуцлагын гэрээ зэрэг бичиг

баримтыг хуулийн дагуу бүрдүүлэн ажиллаж, тайлан, мэдээг гарган ажилласан болно.

2022 онд В-1, В-2, В-3 блоқд ашиглалтын үйл ажиллагаа явагдсан. Уурхайн бэлтгэл ажил болох шинээр ажилчдын хотхон тохижуулах, засварын газар барих, технологийн зам, зогсоолын талбай байгуулах зэрэг ажил хийгдсэн бөгөөд уурхайн үндсэн хөрс хуулалтын ажил 7-р сараас эхэлсэн.

10-р сарын 01-ний байдлаар 776.3 мян.м3 хөрс хуулалт хийж ил уурхайгаас гарсан бүх хөрсийг дотоод овоолго хийсэн.

2. ТӨСЛӨӨС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Хөрс хуулах, хөрс тээвэрлэх, элс олборлох, аж ахуйн ажил гэх мэт үйл ажиллагааны үед машин, техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх.
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хий нь агаарт хаягдаж тухайн орчны агаарын чанарт нөлөөлж болзошгүй.
- ✓ Тоосжилт, хорт хийн ялгаралт, дуу шуугиан гэх мэтээс шалтгаалан төсөл хэрэгжих орчны ойр орчмын айл өрхийн амгалан тайван байдал алдагдах, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй.

2.2. Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Хөрс хуулалтаас газрын гадаргын унаган төрх өөрчлөгдөх.
- ✓ Тээвэрлэлтийн үед үүсэх тоос, шорооны улмаас газрын гадарга тоосонд дарагдах, бохирдох.
- ✓ Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга элэгдэлд орох, хэв шинж өөрчлөгдөх.
- ✓ Газрын гадаргад хоосон (ухсан) орон зай үүсэх.

2.3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Алт агуулсан элс угаах тоног төхөөрөмжийг байрлуулах үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах.
- ✓ Хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.
- ✓ Бензин, тос, дизель (шатах тослох материал) зэргийн асгаралт, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүсэх.

2.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн зэрэг бодис алдагдах, хур тунадас болон үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах.
- ✓ Уурхайн ухаш үүсгэх, далан байгуулах, суваг шуудуу татах, хөрс эвдрэлд оруулах зэргээр газрын гадаргын хэлбэр дүрсийг өөрчилснөөр гадаргын урсацын байгалийн унаган тогтоц өөрчлөгдөх.
- ✓ Хур борооны гаралтай эсвэл бусад эх үүсвэр буюу бохирдсон усны шүүрэлт, чөлөөт нэвчилтээр шилжиж ирэх ус тэжээгдэлийн мужаар дамжин газар доорх усыг бохирдуулах.

2.5. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх ухаш, гадаад овоолго болон бусад объектын нөлөөгөөр ургамлан нөмрөг доройтох, устах зэрэг болно.
- ✓ Хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, ургамалан нөмрөг сүйдэх, нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.

3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Очир Ундраа” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаварыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчмыг баримтлан ажиллаж байна.

Жил бүр нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, шинэчлэн сайжруулж хэрэгжүүлэн ажиллаа.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд удирдлага зохион байгуулалт, нөхөн сэргээлт, агаар, хөрс, усан орчин, ургамал, амьтанд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг менежмент зэрэг хэсгүүдэд хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөж сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээг авч ажиллаа.

Орд ашиглах ТЭЗҮ, Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан 2022 онд В-1,В-2,В-3 блокуудад олборлолт явуулсан бөгөөд В-1 болон өмнө олборлолтын явцд нөхөн сэргээгдээгүй үлдсэн хэсгүүд энэ онд техникийн нөхөн сэргээлийн ажил явуулсан.

Төлөвлөгөөт онд нийт **5.4** га нөхөн сэргээлт хийж ажиллаа.

Сөрөг нөлөөллийг бууруулах, биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, хог хаягдлын менежмент, удирдлага зохион байгуулалтын зардал, орчны хяналт шинжилгээ хийхэд шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тооцож хэрэгжүүлэн ажилласан болно. Мөн техникийн нөхөн сэргээлт, байгаль хамгаалах урьдчилан тооцоолох боломжгүй зардлыг үйл ажиллагааны болон үйлдвэрлэлийн зардалд тухай бүр нь тусгаж ажилласан.

Хүснэгт 3. 2022 оны БОМТ-нд тусгагдсан нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардал /мян.төг/	Баримтлах хууль, журам стандарт
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Газрын хянан баталгаа	8,00,000	Агаар, ус, хөрсний холбогдох стандартууд
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн талбай	Үйл ажиллагааны зардалд	Нөхөн сэргээлтийн холбогдох стандартууд
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Орон нутагтай хамтран ажилласан	10,000,000	"Байгаль орчныг хамгаалах" хууль

4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний	Уурхайн бүх ажилчид	2,000,000	Хог хаягдлын стандарт хууль
5	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Уурхайн бүх ажилчид	Үйл ажиллагааны зардал	"Байгаль орчныг хамгаалах" хууль
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Төслийн нөлөөллийн болон нөлөөллийн бус орчин	Газрын хянан баталгаанд	Агаар, ус, хөрсний холбогдох стандартууд
Нийт зардал			20,000,000	

3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

Хөрс хуулалт, тээвэрлэлт, элс олборлох, овоолго үүсгэх, барилга байгууламж барих, зэрэг үйл ажиллагааны үед тоосжилт үүсч төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хий нь агаарт хаягдаж тухайн орчны агаарын чанарт нөлөөлж болзошгүй зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх 5 ажил арга хэмжээ төлөвлөж ажилласан бөгөөд хэрэгжилтийг доор тайлагнав. Үүнд:

Уурхайн технологийн болон дотоод тээвэрлэлтийн зам, зогсоол, талбайд усалгаа хийж чийгшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Уурхайн тээвэрлэлтээс үүсч буй тоосжилтыг бууруулах зорилгоор эргэлтийн усан сан дахь усыг ашиглан, зам талбайн чийгшүүлэлт, усалгааг хуурайшилттай үед тогтмол хийж тоосжилтийг бууруулан ажилласан

Хөрсний зүсэлт хийж дээж авсан цэгийн мэдээлэл. 2022 он (Зүсэлт –1)

Аймаг, сум: *Дархан-Уул, Хонгор сум,* Газрын нэр: *Золуухарын хөндий*
 Байрлал: $49^{\circ} 17' 24.7'' N$ $106^{\circ} 24' 35.9'' E$ Өндөр (д.т.д) = $953 м$
 Газрын гадарга: *Талархаг хөндий* Гадаргын налуу (градус): $1-2^{\circ}$
 Гадаргын хад, хайрга чулуу: *Үгүй Эвдрэл, доройтол: Эвдрэл, доройтолгүй* Ургамлан нөмрөг: *Алаг өвс-үетэн-улалжит бүлгэмдэл 30-35 %-ийн бүрхэцтэй байна.*
4 Хөрсний нэр: Хархүрэн



Хөрсний шинж чанар:

Аш 0-7 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй сийрэгдүү, ургамлын үндэсний тархалт элбэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт үндэсний тархалтаар мэдэгдэхүйц.

А 7-22 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим.

АВ 22-40 см. Гэгээтэй хар хүрэн өнгөтэй, чийгэрхүү, сийрэг, ургамлын үндэсний тархалт багавтар, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй

Хүснэгт- 11. Хөрсний химийн үндсэн шинжүүд (Зүсэлт –1)

Дээж авсан гүн, см	pH _{H2O}	Давс, %	ЦДЧ dS/m	Ялзмаг %	CaCO ₃ %	Срлилцох сууриуд мг-экв/100г		Хөдөлгөөнт элемент, мг/100г		
						Ca ⁺²	Mg ⁺²	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
0-22	7.34	0.031	0.077	2.87	0.00	27	10	0.43	3.2	4
22-40	7.59	0.030	0.074	2.35	0.00	24	12	0.33	3.6	4

Хүснэгт- 12. Хөрсний механик бүрэлдэхүүн (Зүсэлт –1)

Дээж авсан гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)							Механик бүрэлдэхүүн
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
0-22	7.3	54.9	15.9	9.5	5.8	6.6	21.9	Хөнгөн шавранцар
22-40	6.4	55.5	17.3	10.2	4.9	5.7	20.8	Хөнгөн шавранцар

Хөрсний механик бүрэлдэхүүнийг Качинскийн аргаар тодорхойлоход физик шавар (<0.01мм)-ын хэмжээ 21.9-20,8% байх ба тухайн хөрс нь механик бүрэлдэхүүний ангиллаар элсэнцэрт ойр хөнгөн шавранцар хөрстэй байна.

Хөрсний зүсэлт хийж дээж авсан цэгийн мэдээлэл (Зүсэлт –2)

Аймаг, сум: *Дархан-Уул, Хонгор сум,* Газрын нэр: *Золуухарын хөндий*

Байрлал: *49° 17' 35.3" N 106° 23' 51.1" E* Өндөр (д.т.д) = *910 м*

Газрын гадарга: *Талархаг хөндий* Гадаргын налуу (градус): *1°*

Гадаргын хад, хайрга чулуу: *Үгүй* Эвдрэл, доройтол: *Эвдрэл, доройтолгүй*

Ургамлан нөмрөг: *Үетэн-алаг өвст бүлгэмдэл 50-60%-ийн бүрхэцтэй байна.*

5 Хөрсний нэр: Нугархаг хархүрэн



Хөрсний шинж чанар:

Аш 0-5 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй сийрэгдүү, ургамлын үндэсний тархалт элбэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт үндэсний тархалтаар мэдэгдэхүйц.

А 5-23 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим.

АВ 23-38 см. Гэгээтэй хар хүрэн өнгөтэй, чийгтэй, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хад хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй

Хүснэгт- 13. Хөрсний химийн үндсэн шинжүүд (Зүсэлт –2)

Дээж авсан гүн, см	pH _{H2O}	Давс, %	ЦДЧ dS/m	Ялзмаг %	CaCO ₃ %	Срлилцох сууриуд мг-экв/100г		Хөдөлгөөнт элемент, мг/100г		
						Ca ⁺²	Mg ⁺²	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
0-23	7.18	0.031	0.077	3.57	0.00	26	11	0.67	2.5	19
23-38	6.91	0.028	0.071	3.38	0.00	23	9	0.52	3.9	8

Хөрсөн дэх ялзмагийн агууламж 0-23 см-ийн гүнд 3.57%, түүний доод үеийн 23-38 см-ийн гүнд 3.38%, хөрсний урвалын орчин (pH) 7.18-6.91 буюу дээд үедээ сул шүлтлэг, доод үедээ сул хүчиллэг шинжтэй, давсны хэмжээ 0.031-0.028% байна. Цахилгаан дамжуулах чанар (EC_{2.5}) 0.077-0.071 dS/m буюу давшилтгүй, карбонатын агууламжгүй байна. Хөрсөн дэх нитрат азотын хэмжээ 100 г хөрсөнд 0.67-0.52 мг, солилцох сууриуд болох кальцийн хэмжээ 100 г хөрсөнд 26-23 мг-экв, магнийн хэмжээ 11-9 мг-экв, хөдөлгөөнт фосфорын хэмжээ 100 г хөрсөнд 2.5-3.9 мг, калийн хэмжээ 19-8 мг байгаа нь тухайн хөрс үржил шимийн түвшин болон хөрсний шим тэжээлийн бодисын хангамж сайтай буюу дундажаас дээгүүр байна.

Хүснэгт- 14. Хөрсний механик бүрэлдэхүүн (Зүсэлт –2)

Дээж авсан гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)							Механик бүрэлдэхүүн
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
0-23	1.6	51.3	24.3	7.2	8.5	7.1	22.8	Хөнгөн шавранцар
23-38	3.5	42.3	29.4	10.4	7.6	6.8	24.8	Хөнгөн шавранцар

Хөрсний механик бүрэлдэхүүнийг Качинскийн аргаар тодорхойлоход физик шавар (<0.01мм)-ын хэмжээ 22.8-24.8% байх ба тухайн хөрс нь механик бүрэлдэхүүний ангиллаар хөнгөн шавранцар хөрстэй байна.

5.1.1. Хөрсний зүсэлт хийж дээж авсан цэгийн мэдээлэл (Зүсэлт-3)

Аймаг, сум: *Дархан-Уул, Хонгор сум,* Газрын нэр: *Золуухарын хөндий*

Байрлал: *49° 17' 44.3" N 106° 23' 05.8" E* Өндөр (д.т.д) = *925 м*

Газрын гадарга: *Талархаг хөндий* Гадаргын налуу (градус): *3°*

Гадаргын хад, хайрга чулуу: *Үгүй* Эвдрэл, доройтол: *Эвдрэл, доройтолгүй* Ургамлан нөмрөг: *Алаг өвс-үетэн-улалжит бүлгэмдэл 30-35%-ийн бүрхэцтэй байна.*

6 Хөрсний нэр: Бага зэрэг Сайргархаг Хархүрэн



Хөрсний шинж чанар:

Аш 0-4 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй сийрэг, ургамлын үндэсний тархалт элбэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт үндэсний тархалтаар мэдэгдэхүйц.

А 4-22 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим.

АВ 22-35 см. Гэгээтэй хар хүрэн өнгөтэй, чийгэрхүү, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хад хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй.

Хүснэгт- 15. Хөрсний химийн үндсэн шинжүүд (Зүсэлт-3)

Дээж авсан гүн, см	pH _{H2O}	Давс, %	ЦДЧ dS/m	Ялзмаг %	CaCO ₃ %	Срлилцох сууриуд мг-экв/100г		Хөдөлгөөнт элемент, мг/100г		
						Ca ⁺²	Mg ⁺²	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
0-22	7.50	0.031	0.077	3.27	0.00	22	12	0.37	3.5	10
22-35	6.84	0.031	0.077	2.94	0.00	18	13	0.43	2.2	9

Хөрсөн дэх ялзмагийн агууламж 0-22 см-ийн гүнд 3.27%, доод үеийн 22-35 см-ийн гүнд 2.94%, хөрсний урвалын орчин (pH) 7.50-6.84 буюу дээд үедээ шүлтлэг, доод үедээ сул хүчиллэг шинжтэй, давсны хэмжээ 0.031% байна. Цахилгаан дамжуулах чанар (EC_{2.5}) 0.077 dS/m буюу давсжилтгүй, карбонатын агууламжгүй байна. Хөрсөн дэх нитрат азотын хэмжээ 100 г хөрсөнд 0.37-0.43 мг, солилцох сууриуд болох кальцийн хэмжээ 100 г хөрсөнд 22-18 мг-экв, магнийн хэмжээ 12-13 мг-экв, хөдөлгөөнт фосфорын хэмжээ 100 г хөрсөнд 3.5-2.2 мг, калийн хэмжээ 10-9 мг байгаа нь тухайн хөрс үржил шимийн түвшин болон хөрсний шим тэжээлийн бодисын хангамж дундаж хэмжээтэй байн

Хүснэгт- 16. Хөрсний механик бүрэлдэхүүн (Зүсэлт-3)

Дээж авсан гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)							Механик бүрэлдэхүүн
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
0-22	2.3	42.4	32.2	8.4	6.3	8.5	23.1	Хөнгөн шавранцар
22-35	1.0	41.3	34.8	12.6	2.1	8.2	22.9	Хөнгөн шавранцар

Хөрсний зүсэлт хийж дээж авсан цэгийн мэдээлэл (Зүсэлт-4)

Аймаг, сум: Дархан-Уул, Хонгор сум, Газрын нэр: Золуухарын хөндий
 Байрлал: $49^{\circ} 17' 42.1'' N$ $106^{\circ} 23' 45.8'' E$ Өндөр (д.т.д) = 911 м
 Газрын гадарга: Талархаг хөндий Гадаргын налуу (градус): 1°
 Гадаргын хад, хайрга чулуу: Үгүй Эвдрэл, доройтол: Эвдрэл, доройтолгүй
 Ургамлан нөмрөг: Үетэн-алаг өвст бүлгэмдэл 45-50%-ийн бүрхэцтэй байна.
Хөрсний нэр: Нугархаг Хархүрэн



Хөрсний шинж чанар:

Аш 0-5 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй сийрэг, ургамлын үндэсний тархалт элбэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт үндэсний тархалтаар мэдэгдэхүйц.

Аш 5-20 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим.

АВ 20 см доош. Гэгээтэй хар хүрэн өнгөтэй, чийгэрхүү, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хад хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй.

Хүснэгт- 17. Хөрсний химийн үндсэн шинжүүд (Зүсэлт-4)

Дээж авсан гүн, см	pH _{H2O}	Давс, %	ЦДЧ dS/m	Ялзмаг %	CaCO ₃ %	Срлилцох сууриуд мг-экв/100г		Хөдөлгөөнт элемент, мг/100г		
						Ca ⁺²	Mg ⁺²	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
0-20	8.14	0.054	0.136	3.87	0.00	24	13	0.62	3.6	13

Хөрсөн дэх ялзмагийн агууламж 0-20 см-ийн гүнд 3.87%, хөрсний урвалын орчин (pH) 8.14 буюу шүлтлэг шинжтэй, давсны хэмжээ 0.054% байна. Цахилгаан дамжуулах чанар (EC_{2.5}) 0.136 dS/m буюу давсжилтгүй, карбонатын агууламжгүй байна. Хөрсөн дэх нитрат азотын хэмжээ 100 г хөрсөнд 0.62 мг, солилцох сууриуд болох кальцийн хэмжээ 100 г хөрсөнд 24 мг-экв, магнийн хэмжээ 13 мг-экв, хөдөлгөөнт фосфорын хэмжээ 100 г хөрсөнд 3.6 мг, калийн хэмжээ 13 мг байгаа нь

тухайн хөрс үржил шимийн түвшин болон хөрсний шим тэжээлийн бодисын хангамж дундажаас ахиу хэмжээтэй байна.

Хүснэгт- 18. Хөрсний механик бүрэлдэхүүн (Зүсэлт-4)

Дээж авсан гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)							Механик бүрэлдэхүүн
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
0-20	2.6	43.3	27.1	9.4	7.5	10.1	27.0	Хөнгөн шавранцар

Хөрсний механик бүрэлдэхүүнийг Качинскийн аргаар тодорхойлоход физик шавар (<0.01мм)-ын хэмжээ 27.0% байх ба тухайн хөрс механик бүрэлдэхүүний ангиллаар хөнгөн шавранцар хөрстэй байна.

Хөрсний зүсэлт хийж дээж авсан цэгийн мэдээлэл (Зүсэлт-5)

Аймаг, сум: Дархан-Уул, Хонгор сум, Газрын нэр: Золуухарын хөндий
 Байрлал: 49° 17' 43.6" N 106° 23' 26.2" E Өндөр (д.т.д) = 907 м
 Газрын гадарга: Талархаг хөндий Гадаргын налуу (градус): 1°
 Гадаргын хад, хайрга чулуу: үгүй Эвдрэл, доройтол: Эвдрэл, доройтолгүй
 Ургамлан нөмрөг: Үетэн-алаг өвст бүлгэмдэл 45-50%-ийн бүрхэцтэй байна.

Хөрсний нэр: Нугархаг Хархүрэн



Хөрсний шинж чанар:

Аш 0-7 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй сийрэг, ургамлын үндэсний тархалт элбэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт үндэсний тархалтаар мэдэгдэхүйц.

Аш 7-20 см. Хар хүрэн өнгөтэй, чийгтэй, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим.

АВ 20 см доош. Гэгээтэй хар хүрэн өнгөтэй, чийгэрхүү, сийрэг, ургамлын үндэсний тархалт дунд зэрэг, хад хайрга чулуугүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй.

Хүснэгт- 19. Хөрсний химийн үндсэн шинжүүд (Зүсэлт-5)

Дээж авсан гүн, см	pH _{H2O}	Давс, %	ЦДЧ dS/m	Ялзмаг %	CaCO ₃ %	Срлилцох сууриуд мг-экв/100г		Хөдөлгөөнт элемент, мг/100г		
						Ca ⁺²	Mg ⁺²	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
0-20	7.66	0.070	0.176	3.54	0.00	23	12	0.56	4.5	14

Хөрсөн дэх ялзмагийн агууламж 0-20 см-ийн гүнд 3.54%, хөрсний урвалын орчин (pH) 7.66 буюу шүлтлэг шинжтэй, давсны хэмжээ 0.070% байна. Цахилгаан дамжуулах чанар (EC_{2.5}) 0.176 dS/m буюу давшилтгүй, карбонатын агууламжгүй байна. Хөрсөн дэх нитрат азотын хэмжээ 100 г хөрсөнд 0.56 мг, солилцох сууриуд болох кальцийн хэмжээ 100 г хөрсөнд 23 мг-экв, магнийн хэмжээ 12 мг-экв, хөдөлгөөнт фосфорын хэмжээ 100 г хөрсөнд 4.5 мг, калийн хэмжээ 14 мг байгаа нь тухайн хөрс үржил шимийн түвшин болон хөрсний шим тэжээлийн бодисын хангамж дундажаас дээгүүр зэрэглэлд байна.

Хүснэгт- 20. Хөрсний механик бүрэлдэхүүн (Зүсэлт-5)

Дээж авсан гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)							Механик бүрэлдэхүүн
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
0-20	6.6	48.2	19.8	8.8	6.9	9.7	25.4	Хөнгөн шавранцар

Хөрсний механик бүрэлдэхүүнийг Качинскийн аргаар тодорхойлоход физик шавар (<0.01мм)-ын хэмжээ 25.4% байх ба тухайн хөрс механик бүрэлдэхүүний ангиллаар хөнгөн шавранцар хөрстэй байна.

3.1.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Усны сан бүхий газар, түүний онцгой хамгаалалтын бүс, унд ахуйн худгийн эрүүл ахуйн бүс хог хаягдлаар бохирдох, уурхайн үйл ажиллагаанд өртөх, шатах, тослох материал хөрсөнд алдагдаж хур тунадас, үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах, ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулаагүйн улмаас гадаргын усыг бохирдуулж болзошгүй, угаан баяжуулах үйлдвэрлэлийн хяналтгүй, тооцоогүй усны нөөц ашиглалт зэрэг сөрөг нөлөөллийг бууруула арга хэмжээг авч ажиллаа

3.1.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хөрс хуулалт хийх, зам талбай гаргах, баяжуулах үйлдвэр байгуулах үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах, хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй, бензин, тос, дизель (шатах тослох материал) зэргийн асгаралт, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүсэх зэрэг сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах талаар арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа. Уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тэлэлт хийгдэж буй талбай, зам, зогсоолын талбайн шимт хөрсийг тухайн газрын гадаргын хэв шинжийн онцлогоос хамааран 20-40 см орчим зузаан хуулж, овоолго үүсгэн хэлбэржүүлж хадгална.

3.1.4. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Уурхайн ойр орчимд тохиолдох зэрлэг амьтад үргэн дайжих, амьдрах орчин хуваагдах, үүсч болзошгүй гэж БОННУ-ний тайланд тусгасан байдаг. Урьдчилан сэргийлэх, анхааруулга, санамж өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Зэрлэг амьтдыг үргээх, агнах, ургамал түүх зэрэг хууль бус үйлдэл гаргахгүй байх талаар нийт ажилчдад анхааруулж байх.

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Техникийн нөхөн сэргээлтийн ажил 7-р сарын дундаас эхлэн явагдаж өмнөх онд олборлолтод өртсөн хоосон орон зайг гадаад овоо рүү нэмж буулгаагүй бүх хөрсийг дотоод овоолгоор зөөж дүүргэж тэгшилж засах ажил хийгдэж эхэлсэн

“Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх аргачлал”-ын дагуу холбогдох стандартуудад нийцүүлэхийг зорьж ажилласан болно.

Тус онд уулын ажлыг В-1 блокоос эхлүүлсэн бөгөөд 2022 оны 10-р сарын байдлаар нийт 2.6 га талбай шинээр эвдрэлд орсон. Олборлолтын В-1 блокоос төлөвлөлтийн дагуу 501.6 мян.м³ уулын цул хөдөлгөн олборлолтын ажил бүрэн дууссан болно. В-1 блокоос гарсан нийт хөрсийг 100% өнгөрсөн жилүүдэд буй болсон ил уурхайн хоосон орон зай болох 5.4 га талбайд нөхөн дүүргэлт хийж, техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. В-2 нөөцийн блокийн талыг буюу 6,135.0 м² талбайн хөрсийг хуулж, В-1 блокт үүссэн орон зайд нөхөн дүүргэлтийн ажил хийж байна.

Зураг . Нөхөн дүүргэлтийн ажил хийхийн өмнөх харагдах байдал



Зураг . Нөхөн дүүргэлтийн ажлын явцын харагдах байдал



21
21

Зураг 3. Техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал



Зураг . Нөхөн дүүргэлт хийсэн байдал, тэгшилгээ хийх талбай



Зураг . В-1 блокт үүссэн орон зайд нөхөн дүүргэлт хийж байгаа байдал



23
23

7.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны явцад учирч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэл гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх ажлыг тусгасан “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г жил бүр батлуулан ажилладаг.

Үйлдвэрлэлийн болзошгүй осол, гал түймэр, газар хөдлөлт зэрэг аюулын үеийн бэлэн байдлыг ханган ажилласан.

8.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

-2022 онд Хог хаягдалын гэрээг Хонгор сумтай байгуулан, гэрээнд заасны дагуу үйл ажиллагаа явуулж, төлбөрийг төлж ажилласан.

9.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны хууль, тогтоомжийг баримталж, төлөвлөгөө, гэрээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд удирдлага, зохион байгуулалтын ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа. Орон нутагт мэдээ тайлан хүргүүлэх, байгаль хамгаалал нөхөн сэргээлтийн талаар ажлууд хийгдсэн.

2022 онд ажиллах Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Газрын гэрээ, ус ашиглах дүгнэлт, гэрээ, Нийгмийн хариуцлагын гэрээ, хог хаягдлын гэрээг зэрэг хянуулан батлуулж, гэрээ байгуулан ажилласан.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

№	Материал
1	Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
2	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтын хуулбар. /MV-012415/
3	Ус ашиглах гэрээ, дүгнэлт
4	Хогны хаягдлын гэрээ